





## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |    |  |  |   |
|----|--|--|---|
| 1. | Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай |  | 3 |
|----|--|--|---|

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |    |   |           |    |
|----|---|-----------|----|
| 2. | Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 28 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай | Дугаар 40 | 4  |
| 3. | Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 28 дугаар тойргийн нөхөн сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай               | Дугаар 41 | 6  |
| 4. | Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 28 дугаар тойрогт явагдах нөхөн сонгуулийн зардлын тухай                        | Дугаар 42 | 8  |
| 5. | Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох тухай                       | Дугаар 43 | 10 |
| 6. | Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх тухай                      | Дугаар 44 | 12 |

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- |    |   |            |    |
|----|---|------------|----|
| 7. | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн дүрэм батлах тухай | Дугаар 147 | 14 |
|----|---|------------|----|

### МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

- |    |   |  |    |
|----|---|--|----|
| 8. | “Ковид-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээний яаралтай тусламжийн зээл” |  | 17 |
|----|---|--|----|





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 12 дугаар  
сарын 10-ны өдөр

Дугаар 40

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 28 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 28 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийг 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэхээр товлон зарласугай.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 28 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн санал авах ажиллагааг 2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн санал авах өдөртэй хамт явуулахаар тогтоосугай.

3. Энэ тогтоолыг 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 12 дугаар  
сарын 10-ны өдөр

Дугаар 41

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 28 дугаар тойргийн нөхөн сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай**

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 28 дугаар тойрогт явагдах Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн сонгогчдын бүртгэлийн үйл ажиллагаанд бүртгэлийн техник хэрэгслийг, санал авах, тоолох, дүн гаргах үйл ажиллагаанд “New Image Cast” санал тоолох төхөөрөмж хэрэглэхийг тус тус зөвшөөрсүгэй.

2.Энэ тогтоолыг 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**







## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 12 дугаар  
сарын 10-ны өдөр

Дугаар 42

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 28 дугаар тойрогт явагдах нөхөн сонгуулийн зардлын тухай**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 28 дугаар тойргийн нөхөн сонгуулийн зардлыг 2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн зардалд багтаан явуулахаар тооцсугай.

2. Энэ тогтоолыг 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 12 дугаар  
сарын 10-ны өдөр

Дугаар 43

Улаанбаатар  
хот

### **Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсэг, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр Жигжидийн Цэсэн, Гомбожавын Отгонбаяр, Маруушийн Уянга, Дамдины Цоодол, Мянганбуугийн Наранбаатар, Баасанжавын Ганболд нарыг томилсугай.

2. Энэ тогтоолыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 12 дугаар  
сарын 10-ны өдөр

Дугаар 44

Улаанбаатар  
хот

### **Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсэг, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Дэндэвийн Нямсамбуу, Балдангийн Энхмандах, Батжаргалын Батбаяр, Дэшигрэнцэний Оюун-Эрдэнэ, Довдонгийн Цэндсүрэн, Зургаанжингийн Энхболд, Баастын Золбаяр нарын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж байгаа тул Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**





## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 10 дугаар  
сарын 14-ний өдөр

Дугаар 147

Улаанбаатар  
хот

### **Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн дүрэм батлах тухай**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн дүрэм”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Үндэсний зөвлөлийн дүрэм батлах тухай” Засгийн газрын 2011 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 350 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**У.ХҮРЭЛСҮХ**

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД**

**А.АРИУНЗАЯА**

Засгийн газрын 2020 оны  
147 дугаар тогтоолын хавсралт

### **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ**

#### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэ дүрмийн зорилго нь Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн эрх, үүрэг, удирдлага, зохион байгуулалттай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл (цаашид “Үндэсний зөвлөл” гэх) нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, удирдлага, зохицуулалтаар хангах нийгмийн зөвшилцлийн байгууллага мөн.

#### **Хоёр. Үндэсний зөвлөлийн баримтлах зарчим**

2.1. Үндэсний зөвлөл нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

2.1.1. Үндэсний зөвлөлийн шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн байх;

2.1.2. Үндэсний зөвлөлийн шийдвэр нь ил тод, нээлттэй байх;

2.1.3. Нийгмийн түншлэлийн болон төр, хувийн хэвшлийн оролцоог хангах;

2.1.4. Үндэсний зөвлөлийн гишүүд нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

2.1.5. Бие даасан, хараат бус байдлыг хангасан байх.

### **Гурав. Үндэсний зөвлөлийн эрх, үүрэг**

3.1. Үндэсний зөвлөл нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28.8-д заасан бүрэн эрхээс гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих чиглэлээр төрийн захиргааны байгууллагуудад дэмжлэг үзүүлэх;

3.1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар төрийн болон төрийн бус байгууллага, ажил олгогч, ажилтны төлөөллийн байгууллага, иргэдийн санаачилгыг дэмжиж, хамтран ажиллах;

3.1.3. Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрмийг батлах;

3.1.4. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

### **Дөрөв. Үндэсний зөвлөлийн удирдлага, зохион байгуулалт**

4.1. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд хуралдааныг гишүүдийн дийлэнх олонх (бүрэлдэхүүний 75-аас доошгүй хувь) нь оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцно.

4.2. Аливаа асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

4.3. Үндэсний зөвлөлийн шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна. Тогтоолд Үндэсний зөвлөлийн дарга гарын үсэг зурна.





4.4. Үндэсний зөвлөлийн хуралдааны явцад тэмдэглэл хөтөлж, тэмдэглэлд Үндэсний зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

4.5. “Зөвлөлийн хуралдааны дэг”-ийг Үндэсний зөвлөлийн хурлаар баталж мөрдөнө.

4.6. Үндэсний зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Хуралдааныг Үндэсний зөвлөлийн дарга, түүний эзгүйд орлогч дарга зарлан хуралдуулна.

4.7. Үндэсний зөвлөл нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

4.8. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.

4.9. Үндэсний зөвлөлийн ажлын албаны үүргийг хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгж гүйцэтгэнэ. Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга нь хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудлыг хариуцсан ажилтан байна.



## МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР №.МОН-С6

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОН

ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА

ХООРОНДЫН

“КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ЗЭЭЛ”

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР

2020 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 05 -НЫ ӨДӨР

Агуулга

### 1 дүгээр зүйл Зээл

1 дүгээр хэсэг Зээлийн хэмжээ болон зориулалт

2 дугаар хэсэг Зээлийн хөрөнгийн ашиглалт

### 2 дугаар зүйл Эргэн төлөлт, хүү болон Урьдчилгаа шимтгэл

1 дүгээр хэсэг Үндсэн зээлийн төлбөр

2 дугаар хэсэг Хүү болон төлбөр хийх аргачлал

3 дугаар хэсэг Урьдчилгаа шимтгэл болон төлбөр хийх аргачлал

### 3 дугаар зүйл Тусгай нөхцөл

1 дүгээр хэсэг Ерөнхий нөхцөл

2 дугаар хэсэг Худалдан авах ажиллагааны горим

3 дугаар хэсэг Төлбөр хийх горим

4 дүгээр хэсэг Зээлийн захиран зарцуулалт

5 дугаар хэсэг Гарчиг, нэр

6 дугаар хэсэг Мэдэгдэл болон хүсэлт



Хавсралт №1	Хөтөлбөрийн тодорхойлолт
Хавсралт №2	Зээлийн хөрөнгийн ашиглалт
Хавсралт №3	Зээлийн эргэн төлөлтийн хуваарь
Хавсралт №4	Худалдан авах ажиллагааны горим
Хавсралт №5	Төлбөр хийх горим

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР болон ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА хооронд 2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр байгуулсан Зээлийн хэлэлцээр No-МОН-С6

Монгол Улсын хөгжил, эдийн засгийн тогтворжуулах хүчин чармайлтыг дэмжих зорилгоор Япон Улсаас олгох зээлийн талаар МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР болон ЯПОН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР хоорондын 2020 оны 10 дугаар сарын 09-ний өдөр солилцсон Ноот бичгийг үндэс болгон,

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР (цаашид “Зээлдэгч” гэх) болон ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА (цаашид “ЯОУХАБ” гэх) хооронд дараах Зээлийн хэлэлцээр (энэхүү хэлэлцээрт хавсаргасан бүх тохиролцоог оролцуулан цаашид “Зээлийн хэлэлцээр” гэх) -ийг байгуулав.

## **1 ДҮГЭЭР ЗҮЙЛ**

### **Зээл**

#### **1 дүгээр хэсэг. Зээлийн хэмжээ болон зориулалт**

ЯОУХАБ нь энэхүү хэлэлцээрийн Хавсралт 1-д заасан “Ковид-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээний яаралтай тусламжийн зээл” (цаашид “Хөтөлбөр” гэх)-ийг хэрэгжүүлэхэд зориулан хорин таван тэрбум (25,000,000,000.00) японы иенээс илүүгүй хэмжээний зээл (цаашид “Зээл” гэх)-ийг энэхүү Зээлийн хэлэлцээрт заасан нөхцөлөөр, Япон Улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу Зээлдэгчид олгохыг зөвшөөрсөн бөгөөд ингэхдээ Зээлийн хэлэлцээрийн хүрээнд хийгдэх зарцуулалтын нийт хэмжээ дээр дурдсан хэмжээнд хүрмэгц ЯОУХАБ цаашид зарцуулалт хийхгүй болно.

#### **2 дугаар хэсэг. Зээлийн хөрөнгийн ашиглалт**

(1)Зээлдэгч нь Хавсралт 2-т заасан хуваарийн дагуу Монгол Улсын эрх бүхий байгууллагаас зарцуулсан эсхүл зарцуулах төсвийн зарлагыг санхүүжүүлэх зорилгоор зээлийн хөрөнгийг ашиглана.

(2)Зээлдэгч нь Зээлийн хөрөнгийн ашиглалтын гүйлгээ болгоны үнийн дүнг Хавсралт 5-ын 2 дугаар хэсэгт заасны дагуу Зээлдэгчийн оршин суугч бус иений данснаас Монгол банкна дахь иений данс руу байршуулах бөгөөд ашиглалтын ижил дүнг Зээлдэгчийн төсвийн удирдлагын системд ЯОУХАБ-ын хүлээн зөвшөөрсөн хэлбэрээр бүртгэнэ.

(3)Хэрэв ЯОУХАБ болон Зээлдэгч өөрөөр хэлэлцэн тохиролцоогүй бол Зээлийн хэлэлцээрийн дагуу хийх эцсийн зарцуулалтыг Зээлийн хэлэлцээр хүчинтэй болсон өдрөөс хойш нэг (1) жилийн дараах тухайн сар, өдрийн дотор (цаашид “Зарцуулалтын хугацаа” гэх) хийж дуусгах бөгөөд Зарцуулалтын хугацаа дууссанаас хойш ЯОУХАБ ямар нэгэн зарцуулалт хийхгүй.

(4)Дээрх 2 дугаар хэсгийн (3)-т зааснаас үл хамааран, зарцуулалтын эцсийн хугацаа нь Япон Улсад банкны ажлын бус өдөр байх тохиолдолд Япон Улсад банк ажиллах дараагийн өдөр нь Зарцуулалтын эцсийн хугацаа болно.

(5)Дээрх 1 дүгээр хэсэг болон 2 дугаар хэсэг (1)-т заасныг үл хамааран, 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө санхүүжигдсэн төсвийн зардалтай холбоотой зарцуулалт хийхгүй.

## **2 ДУГААР ЗҮЙЛ**

### **Эргэн төлөлт, хүү болон урьдчилгаа шимтгэл**

#### **1 дүгээр хэсэг. Үндсэн зээлийн төлбөр**

Зээлдэгч нь үндсэн зээлийг энэхүү хэлэлцээрийн Хавсралт 3-т заасан Зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу ЯОУХАБ-д эргүүлэн төлнө.

#### **2 дугаар хэсэг. Хүү болон төлбөр хийх арга**

Зээлдэгч зээлийн хүүг жил бүрийн 5 дугаар сарын 20-ны өдөр болон 11 дүгээр сарын 20-ны өдөр ( цаашид төлбөр төлөх өдөр тус бүрийг “Төлбөр төлөх өдөр” гэх) үндсэн зээл болон зээлийн үлдэгдэлд тэг зууны нэг хувь (0.01%) - тай тэнцэх хэмжээгээр жилийн хүүг тооцож зээлийн хүү төлөх бүрд ЯОУХАБ-д төлнө.

#### **3 дугаар хэсэг. Урьдчилгаа шимтгэл болон Төлбөр хийх арга**

Зээлдэгч нь Ерөнхий нөхцөлийн 3.05-д дурдсан Урьдчилгаа шимтгэлийг төлнө.



### 3 ДУГААР ЗҮЙЛ Тусгай нөхцөл

#### 1 дүгээр хэсэг. Ерөнхий нөхцөл

Энэхүү Зээлийн хэлэлцээрт үйлчлэх бусад ерөнхий нөхцөлийг 2014 оны 11 дүгээр сард ЯОУХАБ-аас гаргасан Хөгжлийн албан ёсны тусламж (ХАЁТ)-ийн Зээлийн ерөнхий нөхцөл (цаашид “Ерөнхий нөхцөл” гэх)-д заасан ба үүнээс гадна дараах нэмэлт зохицуулалт хамаарна. Үүнд:

(1) Ерөнхий нөхцөлийн 2.01 хэсгийн (к)-д заасныг дараах байдлаар ойлгоно:

(к) “Урьдчилгаа шимтгэл” гэж Зээлдэгч нь ЯОУХАБ-д төлөх зээлийн дээд хэмжээний тэг аравны нэг хувь (0.1%)-тай тэнцэх хэмжээний төлбөрийг хэлнэ.

(2) Ерөнхий нөхцөлийн 3.05 хэсгийн (1)-д заасныг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

(1) Зээлдэгч нь Урьдчилгаа шимтгэлийг Зээлийн хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдөр, эсвэл уг өдрөөс хойш хэдийд ч Зээлийн төлбөрийн хүсэлт ирүүлэн, гэхдээ төлбөрийн дүн нь Урьдчилгаа шимтгэлээс их байх бөгөөд төлбөрийн үнийн дүнгээс Урьдчилгаа шимтгэлийг хасан зарцуулалт хийх замаар төлнө. Зээлдэгч нь энэхүү хасагдсан төлбөрийг ЯОУХАБ-д төлсөн Урьдчилгаа шимтгэл гэж бүртгэн, хөрөнгийг зарцуулсан нотолгоог хадгалж, бүртгэнэ.

(3) Ерөнхий нөхцөлийн 3.05 хэсгийн (2)-т заасныг хэрэгсэхгүй.

(4) Ерөнхий нөхцөлийн 3.08 хэсгийн (1)–т заасантай холбогдуулан Зээлдэгч нь зээлтэй холбоотой хийгдэх эргэн төлөлтүүд болон эсхүл үндсэн төлбөрийн эргэн төлөлт, нөхөн төлбөр, хүү болон Зээлийн хэлэлцээрийн дагуу хийх бусад бүх төлбөр тооцоог Токио, Эм-Юү-Эф-Жэй Банкны Төв салбар дахь “ЯОУХАБ-ын зээл” -ийн 0207787 дансанд шилжүүлнэ.

(5) Ерөнхий нөхцөлийн 5.07 хэсгийн (3)-т заасан Төлбөр хийх урьдчилсан нөхцөлийг дор дурдсанаар орлуулна.

(3) Зээлдэгч нь Урьдчилгаа шимтгэлийн нийт дүнг төлбөрийн дүнгээс хасахыг ЯОУХАБ-д зөвшөөрсөн төлбөрийн хүсэлтийг ирүүлнэ.

(6) Ерөнхий нөхцөлийн 6.01 хэсгийн (i)-д дор дурдсаныг нэмнэ.

(i)Хөтөлбөр буюу түүний чухал хэсэг нь хэрэгжих боломжгүй болох нөхцөл байдал.

## **2 дугаар хэсэг. Худалдан авах ажиллагааны горим**

Ерөнхий нөхцөлийн 4.01-д заасан худалдан авах ажиллагааны горимыг энэхүү хэлэлцээрийн Хавсралт 4-т тодорхойлов.

## **3 дугаар хэсэг. Төлбөр хийх горим**

Ерөнхий нөхцөлийн 5.01-д заасан зээлийн төлбөр хийх горимыг дор дурдав.

(1) Хавсралт 5-т заасан Төлбөр хийх горим нь 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр буюу түүнээс хойш хугацаанд зарцуулсан болон эсхүл зарцуулах төсвийн зарлагыг санхүүжүүлэх зорилгоор зээлийн хөрөнгийг ашиглахад мөрдлөг болгоно.

(2) Зээлийн хөрөнгийн ашиглалт нь Япон Улсын Засгийн газраас ЯОУХАБ-д хуваарилагдах төсвийн хязгаарт багтана.

## **4 дүгээр хэсэг. Зээлийн захиран зарцуулалт**

(1) Зээлдэгч болон ЯОУХАБ нь аль нэг талын хүсэлтээр Хөтөлбөрийн хэрэгжилтийн ахицын талаар тодорхой хугацаанд санал солилцоно.

(2) Дээрх 4 дүгээр хэсгийн (1)-д дурдсан санал солилцохын өмнө, Зээлдэгч нь ЯОУХАБ-аас үндэслэлтэйгээр хүссэн нарийвчлалын дагуу Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг ЯОУХАБ-д хүргүүлж, санал авна.

(3) Хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараа ЯОУХАБ-аас үндэслэлтэйгээр хүссэн нарийвчлалын дагуу хөтөлбөрийн эцсийн тайланг шуурхай буюу ямар ч тохиолдолд хөтөлбөр хэрэгжүүлж дууссанаас хойш нэг жилээс хэтрэлгүйгээр гаргаж өгнө.

(4) Зээлдэгч нь Зээлийн хэлэлцээрийн хүрээнд төсвийн зарлагыг санхүүжүүлсэн нотлох бүхий л баримт (гэрээ, захиалга, нэхэмжлэх, төлбөр, тооцооны баримт болон бусад баримт бичиг)-ыг хөтөлбөр хэрэгжиж дууссанаас хойш тав (5)-н жилийн хугацаанд хадгална. Зээлдэгч нь Зээлийн хэлэлцээрийн хүрээнд хийгдсэн ижил төстэй төсвийн зарлагыг бусад авах боломжтой аливаа зээл, буцалтгүй тусламжаар санхүүжүүлэхгүй. Зээлдэгч нь эдгээр баримт бичиг болон бусад холбогдох баримт бичгийг ЯОУХАБ – аас үндэслэлтэйгээр хүссэний дагуу шалгахыг зөвшөөрнө.

## **5 дугаар хэсэг. Гарчиг, нэр**

Зээлийн хэлэлцээрт дурдсан Агуулга болон зүйл, хэсгийн гарчгийг зөвхөн хэрэглэхэд хялбар дөхөм болгох үүднээс оруулсан болно. Эдгээр



нь Зээлийн хэлэлцээрийн бүрэлдэхүүн хэсэг биш бөгөөд Зээлийн хэлэлцээрийн бүтцэд нөлөөлөхгүй бөгөөд мөн хэлэлцээрийг тайлбарлахад авч үзэхгүй.

**6 дугаар хэсэг. Мэдэгдэл болон хүсэлт**

Ерөнхий нөхцөлийн 9.03 дугаар хэсгийн заалтыг хэрэгжүүлэхэд дараах хаягийг ашиглана. Үүнд:

**ЯОУХАБ:**

Шуудангийн хаяг: Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага  
Монгол дахь Төлөөлөгчийн газар  
Сүхбаатарын талбай 3, Бодь цамхаг, 7 дугаар давхар  
Улаанбаатар хот, Монгол Улс

Хэнд: Төлөөлөгчийн газрын дарга

**ЗЭЭЛДЭГЧ:**

Шуудангийн хаяг: Сангийн яам  
Засгийн газрын 2 дугаар байр, С.Данзангийн гудамж 5/1  
Улаанбаатар хот, Монгол Улс

Хэнд: Сангийн сайд

Хэрэв дээр дурдсан хаяг эсвэл нэрс өөрчлөгдвөл холбогдох тал нь шинэ хаяг эсвэл нэрсийн өөрчлөлтийн талаар нөгөө талдаа бичгээр яаралтай мэдэгдэнэ.

Үүнийг гэрчлэн, ЯОУХАБ болон Зээлдэгч нар нь өөрсдийн эрх бүхий төлөөлөгч нараар дамжуулан Зээлийн хэлэлцээрийн гүйцэтгэлийг хангахаар Монгол Улсын Улаанбаатар хотноо тус Зээлийн хэлэлцээрийг үйлдэв.

**ЯПОНЫ ОЛОН УЛСЫН  
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ  
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ  
ТӨЛӨӨЛЖ**

**Гарын үсэг**

**Гарын үсэг**

**ТАМУРА ЭРИКО**

**ЧИМЭДИЙН ХҮРЭЛБААТАР**

**ЯОУХАБ-ын Монгол дахь**

**Сангийн сайд**

**Төлөөлөгчийн газрын дарга**

## Хавсралт 1

### Хөтөлбөрийн тодорхойлолт

#### Хэсэг 1. Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь Монгол Улсын Засгийн газрын эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийг хамгаалах, эмзэг бүлгийн иргэдийг дэмжих арга хэмжээг хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэн КОВИД-19 (коронавируст халдварын цар тахал 2019) цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулан Монгол Улсын эдийн засгийг тогтворжуулахад оршино.

#### Хэсэг 2. Хөтөлбөрийн агуулга

Хөтөлбөрийн агуулга нь 2020 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээний яаралтай тусламжийн зээлийн тухай хөгжлийн бодлогын захиатай ижил байна.

## Хавсралт 2

### Зээлийн хөрөнгийн ашиглалт

Хэсэг 1. Энэхүү Хавсралтад заасан буюу дурдсан нөхцөлүүдийн дагуу төсвийн зарлагыг санхүүжүүлэх зорилгоор зээлийн хөрөнгийг ашиглана.

Хэсэг 2. Дээрх Хэсэг 1-ийн заалтыг үл харгалзан, дараах зүйлсийг зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй:

(1) Дараах ОУХАС\* бүлгүүд, түүний дэд бүлгүүд болон дараагийн бүлгүүд, эсхүл ОУХАС-д цаашид хийгдэж болох өөрчлөлтүүдийн хүрээнд байгуулагдсан дэд бүлгүүдэд багтсан барааны төсвийн зарлага;

Бүлэг	ОУХАС код	Бараа, бүтээгдэхүүний тодорхойлолт
112		Согтууруулах ундаа
121		Тамхи, бүрэн үйлдвэрлэгдээгүй тамхи
122		Үйлдвэрлэсэн тамхи (тамхи орлогч агуулсан ба эс агуулсан)
525		Цацраг идэвхт болон холбогдох материал





667		Сувд, үнэт болон хагас үнэт чулуу, /боловсруулсан, боловсруулаагүй/
718	Дэд бүлэг 718.7	Цөмийн реактор, тэдгээрийн эд анги; Түлшний элементүүд (хайрцагнууд), цацраг идэвхт бус, цөмийн реакторын төрөл
728	Дэд бүлэг 728.43	Тамхины бэлдмэлийг үйлдвэрлэх тоног төхөөрөмж.
897	Дэд бүлэг 897.3	Алт, мөнгө, цагаан алтны бүлгийн металл (цаг, цагны тохиолдлоос бусад), алтны дархан, мөнгөний дарханы эдлэл (үнэт чулуу гэх мэт)
971		Алт (алтны хүдэр, баяжмалыг оруулаагүй)

\* Тайлбар “ОУХАС” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын No.M34/Rev.4 (2006) дугаар Статистикийн баримт бичигт хэвлэн гаргасан Олон улсын худалдааны стандартчилал (4 дүгээр шинэчилсэн найруулга)-ыг хэлнэ.

(2) Аливаа зэвсгийн төрөл;

(3) Байгаль орчинд хор хөнөөлтэй аливаа бараа (Энэхүү заалтын хүрээнд “байгаль орчинд хор хөнөөлтэй бараа” гэж Монгол Улсын хууль тогтоомж болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр хориглосон аливаа бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт болон импортыг хэлнэ);

(4) 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнөх төсвийн зарлага санхүүжилт;

(5) Бараа бүтээгдэхүүнд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ногдуулсан татвар, эсхүл түүний үйлдвэрлэл, импорт эсхүл худалдан авалт болон нийлүүлэлтэд ногдуулах татвар; болон

(6) Энэхүү зээлээс бусад албан ёсны тусламжийн эх үүсвэрээр санхүүжүүлэх, эсхүл санхүүжүүлж байгаа хэлэлцээрийн хүрээнд нийлүүлсэн бараа бүтээгдэхүүний төсвийн зарлага.

### Хавсралт 3

#### Эргэн төлөлтийн хуваарь

Төлбөр хийх огноо	Дүн (Японы иен)
2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр	1,086,968,000
Жил бүрийн 5 дугаар сарын 20-ны өдөр болон 11 дүгээр сарын 20-ны өдөр	1,086,956,000
2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрөөс эхэлж, 2035 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр дуусгавар болно.	

### Хавсралт 4

#### Худалдан авах ажиллагааны горим

Хэсэг 1.Зээлийн хүрээнд хийх худалдан авалтад ашиглах журам

Зээлийн хөрөнгөөс санхүүжүүлэх бүх бараа, үйлчилгээний худалдан авалт нь 2012 оны 4 дүгээр сард байгуулагдсан Японы ХАЁТ-ийн зээл /цаашид «**Худалдан авах ажиллагааны журам**» гэх/ -ийн Худалдан авах ажиллагааны журамтай нийцсэн байна.

Хэсэг 2.Бараа, үйлчилгээг худалдан авахтай холбоотой шийдвэрт ЯОУХАБ -ын хийх хяналт

(1) Дараах нөхцөл байдлын аль нэг үүссэн тохиолдолд ЯОУХАБ-ын зүгээс Худалдан авалтын журмын Хэсэг 1.03.(1)-т заасны дагуу Олон улсын өрсөлдөөнт тендерээс бусад горимыг авч үзэж болно:

- (а) Гэрээний дүн Таван зуун сая (500,000,000) иен эсхүл олон улсын төлбөр тооцоонд хүлээн зөвшөөрсөн валют нь түүнтэй дүйцэхүйц дүнгээс хэтрэхгүй тохиолдолд;
- (б) Мэргэшсэн нийлүүлэгчдийн тоо хязгаарлагдмал тохиолдолд;
- (в) Тоног төхөөрөмжийн солилцоо, стандартчиллыг хангахын тулд эсхүл тусгай загварын шаардлагын улмаас тодорхой брэнд, тэмдэглэгээ, тодорхойлолт бүхий бараа бүтээгдэхүүнийг худалдан авах зайлшгүй шаардлагатай тохиолдолд; болон
- (г) ЯОУХАБ нь Олон улсын өрсөлдөөнт тендерийг (а), (б) ба (в) дүгээр зүйлд зааснаас бусад шалтгааны улмаас тохиромжгүй гэж үзсэн тохиолдолд (яаралтай худалдан авалт хийх тохиолдолд).



- (2) Дээрх 2(1) хэсгийн заалтыг үл харгалзан, дотоодын валютаар санхүүжүүлэх аливаа бараа, үйлчилгээний худалдан авалтад Худалдан авах ажиллагааны журам ашиглахгүй. Гэсэн хэдий ч бараа үйлчилгээг худалдан авах ажиллагааны гэрээ байгуулахад хэмнэлттэй байх, үр ашигтай байх, худалдан авах үйл ажиллагаа нь ил тод байх, эрх бүхий оролцогчдыг үл ялгаварлах зарчмыг харгалзах ёстой.

## **Хавсралт 5**

### **Төлбөр хийх горим**

Энэхүү заалтын хүрээнд тусгасан Төлбөр хийх горим нь Зээлийн хөрөнгийг зарцуулахад ашиглагдана:

Энэхүү хавсралтын аль ч хэсэгт дурдсан Токио дахь гадаад төлбөр тооцооны томилогдсон банк нь Токио, Эм-Юү-Эф-Жи банк байна.

Энэхүү хавсралтын аль ч хэсэгт дурдсан Агент банк нь Монголбанк байх бөгөөд энэ нь Зээлдэгчийн нутаг дэвсгэрт байрлах гадаад төлбөр тооцооны томилогдсон банк юм.

#### **Хэсэг 1. Төлбөр хийх хүсэлт**

(1) Зээлдэгч нь энэхүү Хэлэлцээрт хавсаргасан JICA-RFD(P) маягтад заасны дагуу төлбөр хийх хүсэлтийг ЯОУХАБ-д илгээнэ.

(2) Төлбөр хийх хүсэлтэд заасан дүн нь Японы иенээр тооцсон дүн байна.

(3) Зээлдэгчийн дээрх (1) дэх хэсэгт заасан төлбөрийн хүсэлтээ ЯОУХАБ (i) Зарцуулалтын хугацаа дуусахаас өмнө болон (ii) ЯОУХАБ-д Зээлдэгч төлбөр хийх хүсэлт гаргасан өдрөөс ажлын 15 хоногийн өмнө шаардлагатай баримт бичгийн хамт хүлээн авахаар гаргана.

#### **Хэсэг 2. Санхүүжилт**

(1) ЯОУХАБ нь Төлбөр хийх хүсэлтийг Зээлийн хэлэлцээрийн заалтын дагуу хийгдсэн болохыг тодорхойлж, уг хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 хоногийн дотор Японы иенээр тооцож, Япон Улсын холбогдох хууль, журмын дагуу Токио дахь томилогдсон банк (цаашид “Төлбөр төлөгч банк” гэх)-тай хамтран Зээлдэгчийн нэрийн өмнөөс урьдчилан нээсэн оршин суугч бус иений данс (цаашид “Зээлийн данс”

гэх)-д байршуулна. Энэхүү 2(1) заалтын дагуу ЯОУХАБ-аас хийгдсэн бүх санхүүжилтийг Зээлдэгчийн өмнөөс Агент банк хүлээн авна.

(2) Зээлийн санхүүжилтийг Зээлийн дансанд байршуулж, Төлбөр төлөгч банкнаас мэдэгдэл авсны дараа, Зээлдэгч нь Агент банкаар дамжуулан Зээлдэгчийн томилсон ба ЯОУХАБ-ын хүлээн зөвшөөрсөн Агент банкны Японы иений дансанд шилжүүлнэ.

(3) Зээлийн хөрөнгийг дээрх заалтын дагуу Зээлдэгчийн холбогдох дансанд шилжүүлсний дараа Зээлдэгч нь Агент банкаар дамжуулан Японы иенийг Монгол төгрөгт хөрвүүлэн, Сангийн яамны Монгол банк дахь Улсын төсвийн төсвийн зарлагыг санхүүжүүлэхэд ашиглах Зээлдэгчийн No.3401090 дансанд эсхүл Зээлдэгчийн тодорхойлсон Төрийн сан дахь дансанд байршуулна. Зээлдэгч нь энэхүү шилжүүлэг хийгдсэнээс хойш 30 хоногийн дотор ЯОУХАБ-д санхүүжилт хийгдсэн баталгааг бичгээр олгоно.

### Хэсэг 3. Банкны зохицуулалт

Зээлдэгч нь төлбөр хийхтэй холбоотойгоор аливаа арга хэмжээ авах, эсхүл Төлбөр төлөгч банктай гэрээ, хэлэлцээ хийх зорилгоор Агент банкыг түүний төлөөлөгчөөр томилох бөгөөд энэхүү төлбөрийн журмын дагуу шаардагдах буюу зөвшөөрөгдсөн дараах зүйлийг тусгасан зохицуулалт хийнэ. Гэхдээ энэ нь үүгээр хязгаарлагдахгүй болно.

(1) Зээлдэгчийг төлөөлж Төлбөр төлөгч банканд Зээлийн данс нээх; болон

(2) Зээлийн санхүүжилт Зээлийн дансанд орсны дараа гүйлгээ хийх шаардлагатай зохицуулалтыг баталгаажуулах

(3) Агент банкнаас олгосон эрхийн дагуу Зээлдэгч нь Агент банкнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, зохицуулалтыг дагаж мөрдөх бөгөөд энэхүү зохицуулалт нь гэрээтэй адил үйлчлэх эсхүл зээлдэгч гэрээ байгуулсантай адил хүчин төгөлдөр байна. Зээлдэгч ЯОУХАБ-ын зөвшөөрлийг авсан тохиолдолд Агент банканд олгосон эрхийг хүчингүй болгох эсхүл өөрчилж болно.

### Хэсэг 4. Валютын ханшийн эрсдэл

Зээлдэгч нь зээлийн санхүүжилттэй холбогдуулан валютын ханшны хэлбэлзлээс үүсэх бүх эрсдэлийг хариуцна. ЯОУХАБ үүнд хариуцлага хүлээхгүй.

Маягт JICA-RFD(P)

### Төлбөр хийх хүсэлт

Огноо:  
Зээлийн дугаар.:  
Дэс дугаар.:

Хэнд: Японы Олон Улсын Хамтын ажиллагааны байгууллага  
Монгол дахь Төлөөлөгчийн газар  
Суурин төлөөлөгчийн газрын дарга танаа

Ноёд, хатагтай нар аа:

1. ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА, МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР хооронд 2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр байгуулсан МОН-С6 дугаар бүхий Зээлийн хэлэлцээрийн дагуу би, эрх бүхий этгээд нь нийт 25,000,000,000 (хорин таван тэрбум) Японы иений үнийн дүнтэй санхүүжилтийг хүсч байна.
2. Би, эрх бүхий этгээд нь хүсэлт гаргасан санхүүжилтийг Зээлийн хэлэлцээрийн дагуу санхүүжүүлэх боломжгүй Төсвийн зарлагад зарцуулахгүй байхыг баталгаажуулж байна.
3. Дээрх хүсэлт гаргасан санхүүжилтийн дүнгээс Урьдчилгаа шимтгэл болох 25,000,000 (хорин таван сая) Япон иенийг хасаж, Токио, Эм-Юү-Эф-Жи банк дахь Монгол банкны Зээлийн дансанд шилжүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

Хэнд: \_\_\_\_\_

(Зээлдэгчийн гарын үсэг)

Хэнээс: \_\_\_\_\_

(Баталгаат гарын үсэг)

#### Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turiin\_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.75

Индекс: 200003